

**“Төрийн удирдлага” хөтөлбөрийн сургалтын үйл явцын талаарх
оюутны сэтгэл ханамжийн судалгаа
(ШУТИС-ийн жишээн дээр)**

Д.Одмаа*

*Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль
Бизнесийн удирдлага хүмүүнлэгийн сургууль*

Хураангуй

“Төрийн удирдлага” хөтөлбөрөөр анх сургалт явуулж эхэлсэн сургуулиудын нэг нь ШУТИС-ийн КТМС бөгөөд БСШУ-ны сайдын 1996 оны 03 сарын 09-ний өдрийн 84-р тушаалыг үндэслэн 1998 оноос мэргэжилтэн бэлтгэж эхэлсэн байдаг. Өнөөгийн байдлаар Монгол Улсын хэмжээнд 94 их дээд сургууль үйл ажиллагаа эрхэлж байгаагаас “Төрийн удирдлага”-ын чиглэлээр төрийн өмчийн болон төрийн бус өмчийн 10 их дээд сургууль бакалавр, магистр, докторын түвшинд сургалт явуулж байна. ШУТИС нь өнгөрсөн 20 жилийн хугацаанд тухайн мэргэжлээр 232 бакалавр, 109 магистр төгсгөсөн. Одоо тус хөтөлбөрт 109 бакалавр оюутан, 28 магистрант, 2 докторант суралцаж байна. Манай хамт олон тус хөтөлбөрийг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх, дээд боловсролын тогтолцооны шинэчлэлтэй уялдуулах, чадварлаг боловсон хүчин бэлтгэх тал дээр анхааран ажиллаж байгаа. Үүний хүрээнд багш, суралцагч, төгсөгч, ажил олгогчоос хөтөлбөрийн сургалтын үйл явцын талаарх судалгааг өнгөрсөн жилээс эхлэн үе шаттайгаар авч эхлээд байна.”Төрийн удирдлага” хөтөлбөрийн сургалтын хөтөлбөр, үйл явц түүний үр дүн, уг хичээлийг зааж буй багшийн арга барил, гүйцэтгэл, оюутанд олгосон мэдлэг, ур чадвар, хандлагын талаарх өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлох, цаашид сайжруулах боломж, арга замыг эрэлхийлэхэд уг илтгэлийн зорилго оршиж байгаа. Судалгаанд 2017-2018 оны хичээлийн жилд тус хөтөлбөрт суралцаж буй 72 оюутан хамрагдсан бөгөөд тоон судалгааны үр дүнг • Сургуульд хандах оюутны хандлага • Сургалтын хөтөлбөр, хүртээмж, чанар, үр дүн • Хичээлийн явц, багшийн ур чадвар хэмээн бүлэглэж тус бүрд нь шинжилгээ хийхийг оролдсон болно. Судалгааны үр дүнд сургуульд хандах оюутны хандлага, сэтгэл ханамжийн тухайд мэргэжлийн ном, сурах бичгийн хүрэлцээ хангалтгүй, сургалтын орчин, тоног төхөөрөмж муу, цайны газрын үйлчилгээ тааруу гэх мэт зарим талаараа бидний хэрэгцээг хангаж чадахгүй байна гэж үзжээ. Сурч буй мэргэжлийн давуу талыг судалгаанд оролцогчдын 44.5% нь хөрвөх чадвар сайтай гэж үзсэн бол сул талыг нь ажлын байр хангалтгүй гэж хамгийн их буюу 30% нь хариулсан байна. Түүнчлэн оюутнууд сургалтын хөтөлбөрт тусгагдсан хичээлүүд бидний мэргэжил эзэмших, хөгжих хэрэгцээтэй зарим талаараа нийцдэг гэж 62.5% нь үзсэн бөгөөд 54.8% нь сурч буй мэргэжилдээ сэтгэл дундуур байдаг гэсэн судалгааны үр дүн гарсан. Иймд юуны өмнө сургалтын хөтөлбөрт өөрийн үнэлгээ хийж, одоо байгаа төвшнөө тодорхойлох, түүнд үндэслэн цаашид авч хэрэгжүүлэх үйл ажиллагаагаа төлөвлөн үе шаттайгаар өөрчлөлт, шинэчлэл хийх нь чухал гэж үзлээ.

Түлхүүр үг

Сургалтын орчин, сургалтын хөтөлбөр, багш, суралцагч, мэргэжил

Удиртгал

Дээд боловсролын сургалтын байгууллагын өмнө тавигдаж буй нэг чухал асуудал нь суралцагчдын сэтгэл ханамж, төгсөгчдийн чанар, ажил эрхлэлтийн түвшин юм. Олон улсын туршлагаас харвал өөрийн орны хөгжлийн онцлогт тохирсон, боловсролын болон инновацийн тогтолцоог төлөвшүүлэн, ур чадвартай хүний нөөцийг бэлтгэж, үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлснээр нийгэм, эдийн засгийн хөгжилд нь богино хугацаанд ахиц

дэвшил гарч байна (БСШУСЯ, 2018, х.8). Манай улсын тухайд 2010-2021 онд хэрэгжих Монгол улсын дээд боловсролын шинэчлэлийн зураглал (roadmap)-д “Дээд боловсролын стандарт, сургалтын хөтөлбөр, судалгааны чиглэлийг нийгмийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгох, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн судалгааг өргөжүүлж, ажил олгогч, сургалтын байгууллагын уялдаа холбоог хангах, сургалт, судалгааны орчин, сургалтын хэрэглэгдэхүүн, сурах бичгийг олон

*odmaadangaa@gmail.com

улсын жишигт нийцүүлэх” зэрэг олон асуудлыг тодорхой заасан байна. Манайд хэрэгжиж буй дээд боловсролын шинэчлэл нь боловсролын байгууллагын олон талыг хамарсан, олон шинэлэг ажлууд хийгдэж буй хэдий ч хүссэн үр дүнд хүрэх, олон улсын жишигт хараахан ойртох болоогүй байна. 2017-2018 оны хичээлийн жилд ЕБС-ийг төгсөгчдийн 85.4% нь их, дээд сургуульд элссэн байна. Энэ нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажиллах хүчний зохистой харьцаатай нийцэхгүй байгаа тул цаашид элсэлтийн бодлогод тэнцвэртэй харьцаа бий болгох талаар анхаарах шаардлагатайг харуулж байна (БСШУСЯ, 2018, х.10). 2016 онд судалгаанд хамрагдсан төгсөгчдийн 61.6% нь хөдөлмөр эрхэлж байгаа нь өмнөх оноос 5.1 пунктээр буурсан байна (ХНХЯ, 2016, хууд. 18). Эндээс үзвэл 40% нь шахуу ажилгүйчүүдийн эгнээнд шилжиж байгааг харж болно. Харин манай сургуулийн “Төрийн удирдлага” хөтөлбөрийн төгсөгчдийн ажил эрхлэлтийн байдлыг авч үзвэл (судалгаанд 214 төгсөгч хамрагдсан) 30% нь төрийн байгууллагад, 41% нь хувийн хэвшлийн байгууллагад, 4.6% нь хувиараа бизнес эрхлэгч, 7.5% нь мэргэжил дээшлүүлэн суралцагч, 4.6% нь улс төрийн байгууллага, 2% нь олон улсын байгууллага, 4.6% нь гадаадад амьдарч байгаа төгсөгчид, 3.7% нь ажил эрхлээгүй, 5% нь тодорхойгүй гэсэн судалгааны үр дүнгээс харахад 91,3%-ийн ажил эрхлэлттэй байна (Буянтогтох, 2018, х.11). Гэхдээ төрийн удирдлага мэргэжлээр төгсчхөөд мэргэжлээрээ 30% нь ажиллаж байгаа нь чамлалттай хэдий ч нөгөө талаас энэ мэргэжлийн нийлүүлэлт хангалттай байж магадгүй гэж таамаглаж байна. Иймд нэгэнт их дээд сургуульд элсээд ороод ирсэн оюутнуудыг сурч буй хөтөлбөр, сургалтын орчин, эзэмшиж буй мэдлэг, ур чадвар, хандлагадаа сэтгэл ханамжтай байлгах тал дээр анхаарч ажиллах шаардлагатай гэж үзсэн учраас тус судалгааг хийсэн болно. Судалгаанд 2017-2018 оны хичээлийн жилд тус хөтөлбөрт суралцаж буй 109 оюутнаас 66% нь буюу 72 оюутан хамрагдсан. Судалгаанд оролцогчдыг санамсаргүй түүврийн аргаар сонгосон бөгөөд анкетын аргаар судалгаа авсан.

Сэтгэл ханамжийн онол ба боловсролын үйлчилгээ

Аливаа хэрэглэгчийн гол зорилго нь өөрийн хэрэгцээ шаардлагыг бүрэн хангаж, сэтгэл ханамжтай байх явдал юм. Тэгэхдээ сэтгэл ханамжаа дээд хэмжээнд байлгахыг зорьдог. Энэ талаар судлаачид олон талаас нь судалсан бөгөөд хамгийн түгээмэл чиглэл нь сэтгэл ханамжийн онол юм. Сэтгэл ханамж (satisfaction) гэх нэр томъёог Английн философич И.Бентам (1748-

1832) анх хэрэглэсэн. Гэхдээ тухайн үеийн эрдэмтэд бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэт чанар түүний хэрэглээнээс хэрэглэгчийн олж авч байгаа сэтгэл ханамж хоёрын хоорондын уялдаа холбоог нээж чадаагүй юм (Марал-Үжин, 2018, х.141). Харин Английн эдийн засагч У.Джевонс (1835-1882) хэрэглэгчийн сэтгэл ханамж, үнэ цэнэ хоёр хоорондоо уялдаа холбоотой болохыг тодорхойлоод хэрэглэгч ямар нэгэн бүтээгдэхүүн, үйлчилгээг хүртсэнээр түүнд зохих хэмжээний ханамж үүсдэг гэжээ. Сэтгэл ханамж нь тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээний хүний хэрэгцээг хангах чадвар, шинж чанарыг тусгасан субъектив ойлголт юм. Өөрөөр хэлбэл аливаа бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэснээр өөртөө таатай байдлыг олж авахыг сэтгэл ханамж хэмээн тодорхойлж болно. Тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээ хүний хэрэгцээг хангах чадвартай л бол өөртөө сэтгэл ханамжийг агуулдаг. Түүнчлэн Портер-Лоулериин мотивацийн загвараар хүч чармайлт гаргавал ажлын гүйцэтгэл сайжирч тэр хэрээр сэтгэл ханамж өндөрсдөг буюу эдгээр нь хоорондоо шууд хамааралтай хэмээн үздэг (Увш, Хэрлэн, 2017, х.68). Эндээс үзвэл тухайн бараа үйлчилгээний хэрэглээнээс хүртэж буй ашиг тус, сэтгэл өгч байдлыг ханамж гэж нэрлэдэг.

Дэлхий дахинд үйлчилгээний салбар хурдацтай хөгжиж, үйлчилгээний эдийн засагтай орнуудын тоо нэмэгдсээр байна. Үйлчилгээний салбар хөгжихийн хэрээр энэ салбарт ажиллагсдын тоо улам бүр өсөж, үүний үр дүнд үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын дунд чанарын төлөө өрсөлдөөн бий болж, үйлчилгээний шинэ төрлүүд бий болсоор байна. Үйлчилгээний үйл ажиллагааны мөн чанар нь үйлчилгээг хэрэглэгчийн бодит болон оюуны аль төрлийн хэрэгцээг хангаж буй байдал, нөгөөтэйгүүр хэрэглэгч үйлчилгээг авснаар хэрхэн өөрчлөгдөж байгаа нь үйлчилгээний тархалт, цаг хугацаа, байршил, тогтвортой байдал зэргийг зохицуулахад ач холбогдолтой. Орчин үед үйлчилгээний салбарт үйлчлэгч, хэрэглэгч гэсэн хоёр талт харилцаанд тулгуурласан загвар давамгайлж байна. Өөрийн үйлчлүүлэгч буюу үйлчилгээг хүлээн авагчийн зан төлөв, сэтгэл ханамжийн байдлыг хангахад чиглэсэн байнгын, тогтвортой, үнэнч үйлчлүүлэгчтэй байх талаар олон аргыг хэрэглэх болсон. Энэ нь үйлчилгээг нэг буюу олон хэлбэрээр хэрхэн хүргэх, хэрэглэгчдийн сэтгэл ханамжийг яаж дээшлүүлэх тал дээр байгууллагууд харилцааны инновацийг хийж байна. Эдгээрээс дэлхийн хэмжээнд хамгийн их өсөлттэй байгаа 3 төрлийн үйлчилгээ нь аялал зуучлалын үйлчилгээ, санхүүгийн зөвлөгөө өгөх үйлчилгээ,

боловсролын үйлчилгээ юм (ШУТИС, 2013, х.327). Боловсрол нь жилээс жилд хүний амьдрах чадварын гол хүчин зүйл болохын хэрээр түүний үнэ өртөг ихээхэн нэмэгдэж, ялангуяа дээд боловсролын байгууллагуудын өрсөлдөөн нэмэгдэж, оюутнуудыг татах сургалтын үйл ажиллагааны арга барил ч өөрчлөгдөх болов. Үүнтэй холбоотойгоор боловсролын үйлчилгээний чанар, төгсөгчдийн ур чадвар энэ салбарын тулгамдсан асуудлын нэг болсоор удаж байна. Боловсролын үйлчилгээний чанарыг зах зээл дээр хэрэглэгч шалгадаг (Өлзийхуяг, 2010, х.89) бөгөөд Европын их сургуулиудын удирдлагуудын 91% нь төгсөгчдийн ажил эрхлэлт чухал гэдэгтэй санал нэгдсэн байдаг (ХУИС, 2010, х.41). Боловсролын байгууллага нь ажил олгогчдын хэрэгцээ шаардлагад нийцэхүйц мэдлэг, ур чадвартай төгсөгчдийг бэлдэж гаргахгүй байгаагаас байгууллагууд ур чадвартай ажиллах хүчээр улам бүр дутагдах болсон. Энэ байдлаас гарах эхний алхам нь их, дээд сургуулиуд мэргэжилтэн бэлтгэж буй сургалтын хөтөлбөр тус бүрээрээ судалгаа хийж, оролцогч талуудын сэтгэл ханамжийг тодорхойлж, үр дүнг нь үйл ажиллагаандаа тусгах явдал гэж үзэж байна.

“Төрийн удирдлага” хөтөлбөрийн оюутнуудаас авсан судалгааны үр дүн

1990 онд Монгол орон улс төр эдийн засгийн өөрчлөлт, шилжилтийг хийснээр дээд боловсролын системд шинэчлэл хийгдэж, бэлтгэн гаргах мэргэжилтнүүдийн хүрээ тэлэн шинэ мэргэжил, хөтөлбөрүүд олноор бий болсон. Түүний нэг нь тухайн үеийн ТИС-ийн КТМС-д шинээр нээгдсэн “Төрийн захиргааны менежемент” мэргэжил юм. 1998-1999 оны хичээлийн жилээс анхны элсэлтээ авч, мэргэжилтэн бэлтгээд эдүгээ 20 оныг ардаа үдсэн

байна. Энэ хугацаанд бид бүхэн тус мэргэжлийг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх, дээд боловсролын тогтолцооны шинэчлэлтэй уялдуулах, чадварлаг мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх тал дээр анхааран ажиллаж байна (Нямдулам, Одмаа, 2018, х.5). Орчин үед дэлхий дахинд аливаа сургалт, судалгааны ажлын хөтөлбөрийг боловсруулахдаа суралцагчийн болон нийгмийн бодит хэрэгцээ, сонирхолд суурилах, мэдлэгийг өөрийн идэвхтэй үйл ажиллагаагаар бүтээх хандлагыг чухалчлах, хамтын оролцооны зарчимд үндэслэх, нээлттэй уян хатан болгох, сонголттой хувилбараар хэрэглэх, интеграцилах, инноваци хийх, чадамж, үр дүнд суурилан боловсруулах хандлагыг баримталж байгаа нь их, дээд сургуулийн мэргэжлийн хөтөлбөр түүний агуулга шинэчлэгдэх болсныг илтгэж байна (Д.Одмаа, 2018, х.153). Өөрөөр хэлбэл боловсролын чанарыг үнэлэхдээ сургалтын хүлээгдэж буй үр дүн буюу сургалтын гаралтад төвлөрөх болсонтой уялдан боловсролын стандарт, сургалтын агуулга, хөтөлбөрт өөрчлөлт орж эхэлсэн (Дашжамц, 2006, х.36).

Оюутнаас авсан судалгааны үр дүнг үнэн бодитой байлгах үүднээс бүх курсийн оюутны төлөөллийг хамруулахыг урьтал болгосон. Судалгааны асуултыг боловсруулахдаа

- Сургуульд хандах оюутны хандлага
- Сургалтын хөтөлбөр, чанар, үр дүн
- Хичээлийн явц, үр дүн, багшийн ур чадвар хэмээн бүлэглэж, тус бүрд нь шинжилгээ хийсэн.

Нийт 72 судалгааны анкетын 2 нь хүчингүй байсан учраас 70 анкетаас судалгааны үр дүнг тооцсон. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээллийг дараах хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 1

Судалгаанд оролцогчдын нас, хүйсийн бүтэц (тоогоор илэрхийлбэл)

Оролцогчдын нас, хүйсийн бүтэц		Суралцаж буй курс				
1-р курс		2-р курс	3-р курс	4-р курс	Бусад	
Нас	18	21	2			
	19	1	10	6	1	
	20		1	7	6	
	21			1	6	
	22		1		1	1
	23		1		1	1
	24		1			
Хүйс	25			1		
	Эрэгтэй	9	5	5	5	2
	Эмэгтэй	13	11	10	10	
Судалгаанд оролцогчдын нийт тоо		22	16	15	15	2


Дээрх хүснэгтээс үзвэл судалгаанд хамрагдсан оюутнуудаас 18-19 насны

бүлгийнхний эзлэх хувь хамгийн их байв. Судалгаанд оролцогчдыг хүйсийн бүтцээр нь авч үзвэл эрэгтэй 37.1%, эмэгтэй 62.9%-ийг эзэлж байсан бөгөөд 1-р курсийн 22 оюутан,

2-р курсийн 17 оюутан, 3-р курсийн 15 оюутан, 4-р курсийн 16 оюутан, бусад 2 оюутан тус тус хамрагдсан.

Зураг 1

Та өөрийн сурч буй мэргэжлийн давуу талыг юу гэж боддог вэ?




Зургаас харвал оюутнууд өөрийн мэргэжлийн давуу талыг зах зээлд хөрвөх чадвартай гэж үзсэн байна. Энэ нь дээр дурдсан манай мэргэжлийн төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаагаар 61 % нь мэргэжлийн бус, өөр салбарт ажилладаг гэсэн судалгааны үр дүнг баталж байна. Мөн 18.1 % нь мэргэжилтэн бэлтгэж буй олон жилийн туршлагатай гэж үзжээ. Харин “Та өөрийн сурч буй мэргэжлийн сул талыг юу гэж боддог вэ?” гэсэн нээлттэй асуултад судалгаанд оролцогчдын 33.2 % нь хариулаагүй бөгөөд 29.1 % нь ажлын байр хомс,

8.3 % нь хүмүүс энэ мэргэжлийн талаар тэр бүр мэддэггүй гэж хариулсан байна. Ялангуяа ШУТИС-д ийм мэргэжил эзэмшдэг гэхээр гайхдаг гэжээ. Бусад нь төгсөж гараад цалин бага, олон улсад магадлан итгэмжлэгдээгүй, 2+2, 3+1 гэх мэт хамтарсан хөтөлбөрүүд хэрэгждэггүй, мэргэжлийн ном, сурах бичгийн хангамж хангалтгүй, ажлын байр нь улс төрийн нөхцөл байдал, намаас хамааралтай учир баталгаагүй, авлига хээл хахуульд өртөх магадлалтай гэх мэтээр хариулжээ.

Зураг 2

Сургалтын хөтөлбөрт тусгагдсан хичээлүүд таны мэргэжил эзэмших, хөгжих, хэрэгцээтэй хэрхэн нийцэж байна вэ? (Тоогоор илэрхийлбэл)



Оюутнууд сургалтын хөтөлбөрт тусгагдсан хичээлүүд бидний мэргэжил эзэмших, хөгжих хэрэгцээтэй зарим талаараа нийцдэг гэж 62.5 % нь үзсэн нь тийм ч хангалттай үр дүн биш юм. Хүснэгт 2

Ялангуяа 4-р курсийн ¾ нь ингэж үзэж байгаа нь манай хөтөлбөрийн сургалтын үйл ажиллагаа, чанар, хүртээмжид анхаарал хандуулах цаг болсныг илтгэж байна.

Таны бодлоор оюутнууд мэргэжилдээ...

Сэтгэл хангалуун байдаг		Таны бодлоор оюутнууд мэргэжилдээ...			Нийт
		Сэтгэл дундуур байдаг	Мэдэхгүй		
Та хэддүгээр курст суралцдаг вэ?	1	6	12	4	22
	2	5	8	3	16
	3	6	8	1	15
	4	5	10	0	15
	5	1	1	0	2
Нийт		23	39	8	70

Хүснэгтээс харвал 55% нь сурч буй мэргэжилдээ сэтгэл дундуур байдаг гэсэн судалгааны үр дүн гарсан. Энэ нь тухайн хөтөлбөрийн оюутны сэтгэл ханамж сайн биш байгааг харуулж байна. Уг чанартаа мэргэжлээ зөв сонгох, мэргэжилдээ дуртай байх нь ажилдаа амжилт гаргаж, зорилгодоо хүрч сайхан амьдрах, ирээдүйд манлайлагч болоход нөлөөлдөг гол хүчин зүйл юм (Болор, 2018, х.42). Түүнчлэн 68.6% нь танай сургуульд хийгдэж буй сургалтын

хөтөлбөр, төлөвлөгөөний өөрчлөлтүүд нь таны боловсорч хөгжих хэрэгцээтэй зарим талаараа нийцэж байна, 8.6% нь огт нийцэхгүй, мэдэхгүй гэж хариулсан нь дээрх судалгааны үр дүнг нотолж байна. Иймд цаашид сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө өөрчлөхөд оролцогч талуудын саналыг авах, судалгааны үр дүнд суурилах, нийгмийн эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцүүлэх нь чухал гэж үзлээ.

Хүснэгт 3

Та сурч буй мэргэжлийн хөтөлбөрийг хэрхэн үнэлэх вэ? (Хувиар илэрхийлбэл)

№	Асуулт	1	2	3	4	5	X
1	Мэргэжлийн хөтөлбөрөөр зайлшгүй шаардлагатай мэдлэг эзэмшсэн	2.8	4.2	31.9	45.8	12.5	2.8
2	Мэргэжлийн хөтөлбөрөөр зайлшгүй шаардлагатай ур чадвар эзэмшсэн	4.2	4.2	26.4	47.2	9.7	8.3
3	Мэргэжлийн хөтөлбөрөөр зайлшгүй шаардлагатай дадлыг эзэмшсэн	2.8	8.3	33.3	38.9	9.7	6.9
4	Оюутанд зөв хандлага, сахилга бат, ёс суртахууны төлөвшилийг олгодог		9.7	25	41.7	15.3	8.3
5	Хичээлийн агуулгын давхцал байдаг	2.8	6.9	41.7	26.4	12.5	9.7
6	Сургалтын техник хэрэгслийн хангамж, хүчин чадал, үзүүлэлт хангалттай	2.8	18.1	31.9	29.2	11.1	6.9
7	Ном, сурах бичгийн хүрэлцээ	8.3	34.7	25	9.7	6.9	15.3
8	Мэдлэг чадвараа тэлэх өргөжүүлэх боломжтой, нийгэм соёлын арга хэмжээнүүд зохион байгуулагддаг	5.6	12.5	26.4	31.9	16.7	6.9
9	Бусад их дээд сургуулийн ижил хөтөлбөртэй харьцуулахад манай хөтөлбөр...	1.4	6.9	23.6	36.1	19.4	12.5
10	Бусад						

Хүснэгтэд 1, 2, 3, 4, 5 гэсэн тоогоор үнэлгээний түвшинг өсөх дарааллаар, “Х” гэсэн үсгээр “Хариулаагүй” оюутнуудын хувийг илэрхийлсэн болно. Оюутнууд мэргэжлийн хөтөлбөрөөр зайлшгүй шаардлагатай мэдлэг эзэмшсэн эсэхээ үнэлэхдээ 58.3% нь, ур чадвар эзэмшсэн эсэхээ 57.1% нь, дадал эзэмшсэн эсэхээ 48.6% нь дунджаас дээгүүр байдлаар тус тус үнэлсэн байна. 1, 2-р курсийн оюутнууд мэргэжлийн хөтөлбөрөөр зайлшгүй шаардлагатай мэдлэг, чадвар, дадал эзэмшсэн эсэхээ дунджаас доогуур байдлаар, харин 3, 4-р

курсийн оюутнууд дунджаас дээгүүр байдлаар үнэлсэн нь аргагүй юм. Түүнчлэн хичээлийн агуулгын давхцал ихтэй, сургалтын техник хэрэгслийн хангамж, хүчин чадал, үзүүлэлт, ном, сурах бичгийн хүрэлцээ хангалтгүй, соёл, олон нийтийн арга хэмжээ хангалттай зохион байгуулагддаггүй гэж үнэлжээ. Суралцах нөхцөл нь суралцагчдын хэрэгцээ, сонирхолтой уялдаа холбоотой байвал тэд идэвхтэй суралцана гэж үзэх хандлага түгээмэл байдаг (Даваа, 2015, х.27) учраас энэ тал дээр анхаарал хандуулах нь зүйтэй юм. Өөрийн суралцаж буй хөтөлбөрийг

бусад их дээд сургуулийн ижил хөтөлбөртэй харьцуулахад 55.7% нь дунджаас дээгүүр гэж үнэлснийг дээрх хүснэгтээс харж болно. Энэ бол хангалттай үр дүн биш юм.

Сургалтын хөтөлбөрт зайлшгүй оруулах шаардлагатай шинэ хичээл байна уу? гэж асуухад албан хэрэг хөтлөлт, харилцааны ур чадвар, гадаад хэл, ёс зүй, ТАХ-ийн практик

сургалт семинарын хичээлийг оруулах саналтай байгаагаа илэрхийлсэн бол Сургалтын хөтөлбөрөөс хасах шаардлагатай, чухал ач холбогдолгүй хичээл байна уу? гэхэд хамгийн их санал авсан хичээл нь математик, хүний нөөцийн менежмент, монголын түүх, сэтгэл судлал гэсэн хичээлүүд байв.

Хүснэгт 4

Та хичээлийн явц, үр дүн, багшийн ур чадварыг хэрхэн үнэлэх вэ? (Хувиар илэрхийлбэл)

№	Асуулт	1	2	3	4	5	X
1	Багш нар хичээлийн цагийг үр дүнтэй ашиглаж, агуулгыг сайн ойлгуулж, хичээлдээ анхаардаг		5.6	16.7	50	26.4	1.4
2	Багш нар оюутныг бие даан хөгжих, идэвхжүүлэх бүтээлч сэтгэлгээний аргыг хичээлдээ хэрэглэдэг	1.4	4.2	19.4	56.9	15.3	2.8
3	Танхимд олж авсан онолын мэдлэгээ практикт хэрэглэх боломжтой	1.4	16.7	29.2	29.2	19.4	4.2
4	Та өөрийн сурлагын дүн болон мэдлэгийн харьцааг хэрхэн үнэлдэг вэ?		5.6	36.1	40.3	15.3	2.8
5	Багшийн үнэлгээ бодитой, шударга байдаг		4.2	23.6	38.9	30.6	2.8
6	Та мэргэжлийн багш нарын харилцаа, ёс зүйг ерөнхийд нь хэрхэн үнэлэх вэ?	1.4	4.2	9.7	43.1	37.5	4.2
7	Та мэргэжлийн бус суурь боловсролын хичээлийн багш нарын харилцаа, ёс зүйг ерөнхийд нь хэрхэн үнэлэх вэ?		6.9	19.4	43.1	27.8	2.8
8	Танай мэргэжлийн багш профессорууд оюутнуудынхаа эрдэм шинжилгээ, судалгааны ажилд хэр дэмжлэг, туслалцаа үзүүлдэг вэ?	4.2	4.2	15.3	41.7	27.8	6.9
9	Зөвлөх багшийн үйл ажиллагааг үнэлнэ үү	1.4	4.2	6.9	31.9	52.8	2.8
10	Танай мэргэжлийн багш нар оюутны бие даан суралцах чадварыг хөгжүүлэхэд хэр түлхэц үзүүлдэг вэ?	2.8	5.6	20.8	47.2	18.1	5.6

Дээрх судалгааны үр дүнгээс харвал хичээлийн явц, үр дүн, багшийн ур чадварыг дийлэнх оюутнууд сайн, маш сайн гэж үнэлсэн байна. Харин оюутнуудын 41,7 хувь нь та өөрийн

сурлагын дүн болон мэдлэгийн харьцааг хэрхэн үнэлдэг вэ? гэхэд 3-аас доош үнэлгээ өгсөн бол танхимд олж авсан онолын мэдлэгээ практикт хэрэглэх боломжгүй гэж мөн 47,3 хувь нь үзжээ.

Зураг 3

Таны бодлоор хичээлийн үр дүнд хамгийн их нөлөөлдөг зүйл юу вэ? (Тоогоор илэрхийлбэл)



Эндээс үзвэл багшийн мэдлэг, ур чадвар болон оюутны өөрийн идэвх чармайлт 2 хичээлийн үр дүнд хамгийн их нөлөөлдөг гэж үзсэн байна. Европын холбооны баримт бичигт “шинэчлэлийн явц дахь багшийн үүрэг нь шинэ хэрэгцээ, шаардлагыг хангаж, тасралтгүй хөгжиж, ирээдүйн багшийн шинэ хэв маяг, шинжийг хадгалахыг чухалчилсан” байдаг (Пүрэвдорж, Нэмэхжаргал, 2014, х.175). Багшийн мэргэжил, арга зүйг хөгжүүлэх асуудал нь боловсролын тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлтийн хамгийн чухал асуудал юм. Нэг талаас суралцагчдын амжилттай суралцах эсэх нь багшийн харилцаа, хандлагатай шууд холбоотой (ХСИС, 2017, х.75) гэж үзсэн нь дээрх судалгааны үр дүнг нотолж байна. Оюутнуудын зүгээс багш нарын мэдлэг, ур чадвар, заах арга зүй, харилцаа, хандлагын талаар дараах саналуудыг дэвшүүлжээ. Үүнд:

- Багш нарын ур чадварыг улам илүү сайжруулах хэрэгтэй байна.
- Амьдралд ойр практик жишээ, кейс ашиглаж, олон улсын туршлагаас ярих зэрэг сонирхолтой байдлаар лекц унших, онол, онол, онол ярьсаар хичээл дуусдаг.
- Хойно сууж буй оюутнуудад хүртээмжтэй байдлаар лекц унших, зарим багш нар хэт нам дуугаар лекц уншдаг, зарим нь хэт хурдан ойлгомжгүй заадаг, зарим нь ганцаараа яриад байдаг.


- Зөвхөн РРТ-гээ хараад ярьдаг, харж уншдаг бус тайлбарладаг байх мөн багш цаас тараагаад эсвэл РРТ тавьчихаад өөрөө суугаад байдаг үүнийг болих.
- Лекцийн хичээлийг эхэнд нь оруулж семинарын хичээлийг хойно нь оруулах.
- Лекцийн хичээл болон семинарын хичээлийн агуулга зөрөөд үр дүн багатай байдаг.
- Багш оюутантай нээлттэй харилцах, харилцааны доголдол гаргахгүй байх гэх мэт.

Эдгээрээс багшийн заах арга зүйтэй холбоотой саналууд дийлэнхийг нь эзэлж байгаа нь багш мэргэжилтэй бус, багшлах эрхийн цөөн хоногийн сургалтад суусан багш нар хичээл заадагтай холбоотой байж болох юм.

Таны бодлоор мэдлэг, чадвар, дадал, хандлагыг хангалттай олгоогүй хэмээн үзсэн хичээлийг цаашид хэрхэн сайжруулж болох вэ? гэж асуухад бүх оюутны оролцоог хангах, практикт суурилсан семинарын хичээл явуулах, багаар ажиллуулах, илтгэл тавиулах, оюутныг бүх талаар хөгжүүлэх, семинарын хичээлийн гарын авлагыг бий болгох, оновчтой, тодорхой бие даалт өгөх, бие даалтын тоог багасгах, чанартай цөөн бие даалт өгөх, оюутантай харилцан ярилцах, хамтрах, оюутнуудад жигд шаардлага тавьж, жигд харилцах гэсэн байна.

Зураг 4

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн агуулга, хичээл заах багшийн тухай мэдээллийг хаанаас олж авдаг вэ? (Давхардсан тоогоор илэрхийлбэл)




Зургаас харвал сургалт, багш, хичээлтэй холбоотой мэдээллийг оюутан хоорондын ярианаас, оюутны вебээс, харьяа тэнхим, багш нараас илүүтэй авдаг нь харагдаж байна.

Танд мэргэжлийн чиглэлээс гадна ямар салбарын мэдлэг чухал хэрэгцээтэй байна вэ? гэсэн асуултад оюутнууд хамгийн их давтамжтайгаар харилцааны соёл, техник ур чадвар, хувь хүний хөгжил, карьер хөгжүүлэлт, бүтээлч болон шүүмжлэлт сэтгэлгээ, хууль, эрх

зүйн мэдлэг гэжээ.

Зураг 5

Та одоогийн байдлаар өөрийн мэргэжлээ ямар түвшинд эзэмшсэн гэж бодож байна вэ? (Тоогоор илэрхийлбэл)



Оюутнуудын мэргэжил эзэмшсэн түвшин курс ахих тусам дээшилж байгаа нь зүй ёсны хэрэг бөгөөд өөрсдийгөө хэт өндөр үнэлэхээс зайлсхийсэн байж магадгүй юм. Түүнчлэн 1, 2 дугаар курсын оюутнууд мэргэжлээ бараг эзэмшээгүй гэж өөрсдийгөө бодитоор үнэлсэн байна.

Дүгнэлт

Судалгааны үр дүнд сургуульд хандах оюутны хандлага, сэтгэл ханамжийн тухайд сургалтын орчин, тоног төхөөрөмж, ном сурах бичгийн хангамж гэх мэт зарим талаараа бидний хэрэгцээг хангаж чадахгүй байна гэж үзжээ. Сургалтын хөтөлбөр, чанар, үр дүнгийн хувьд дундаж түвшинд байгаа учраас сургалтын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах, оюутан, багшийн хөгжлийг дэмжих, сургалтын хөтөлбөрт судалгаа, шинжилгээ тогтмол хийх шаардлагатай байна. Судалгаанд оролцогчдын 44.5% нь сурч буй мэргэжлийн давуу талыг хөрвөх чадвар сайтай гэж үзсэн бол сул талыг нь ажлын байр хангалтгүй гэж хамгийн их буюу 30% нь хариулсан байна. Түүнчлэн оюутнууд сургалтын хөтөлбөрт тусгагдсан хичээлүүд бидний мэргэжил эзэмших, хөгжих хэрэгцээтэй зарим талаараа нийцдэг гэж 62.5% нь үзсэн бөгөөд ялангуяа 4-р курсийн $\frac{3}{4}$ нь ингэж үзэж байгаа нь манай хөтөлбөрийн сургалтын үйл ажиллагаа, чанар, хүртээмжид анхаарал хандуулах цаг болсныг илтгэж байна. Хичээлийн явц, үр дүн, багшийн ур чадварын тухайд хичээлүүдийн агуулгын давхардлыг арилгах, лекц, семинарын хичээлийн уялдаа холбоог хангах, багш нарын заах арга зүйн ур чадварыг дээшлүүлэх хэрэгтэй байна гэжээ. Түүнчлэн 54.8% нь сурч буй мэргэжилдээ сэтгэл дундуур байдаг гэсэн судалгааны үр дүнгээс харвал тус хөтөлбөрөөр суралцаж буй оюутнуудын сэтгэл ханамж хангалттай түвшинд хүрэхгүй байна гэсэн дүгнэлтэд хүрлээ.

Санал

Дээрх судалгааны үр дүнд үндэслэн ШУТИС-ийн “Төрийн удирдлага” хөтөлбөрийн сургалтын үйл явцыг илүү сайжруулах дараах саналуудыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Юуны өмнө хөтөлбөр өөрийн үнэлгээ хийж, одоо байгаа түвшингөө тодорхойлсны дараа хэрхэн сайжруулж болох гарц, шийдлийг хайх
2. Оюутны шилжилт хөдөлгөөн их байдаг учраас анх элсэхэд мэргэжлийн хөтөлбөрийн танилцуулгыг хийж, мэргэжлийн чиг баримжаа олгох
3. Хөтөлбөрт оролцогч талуудын судалгааг тогтмол хийж, үр дүнг нь үйл ажиллагаандаа тусган ажиллах
4. Гадаад, дотоод хамтын ажиллагаа өргөжүүлэх, ялангуяа хамтарсан хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, дадлага хийх байгууллагуудтай гэрээ байгуулах
5. Багш нарын заах арга зүй, ур чадварыг дээшлүүлэх сургалт, семинар зохион байгуулах, мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах, багшийн харилцаа, ёс зүйн тал дээр анхаарах
6. Оюутны олон талт чадварыг хөгжүүлэх тал дээр анхаарч, төрөл бүрийн арга хэмжээг тогтмол зохион байгуулах
7. Сургалтын орчинг сайжруулах, мэргэжлийн кабинеттай болох
8. Мэргэжлийн эрэлт хэрэгцээ, ажлын байрны нийлүүлэлт, төрийн өмчийн сургуулиудын ижил мэргэжлээр мэргэжилтэн бэлтгэх явдлыг цэгцлэх зэрэг асуудлыг төрийн бодлогын хэмжээнд шийдвэрлэж, зохицуулалт хийх зэрэг болно.

Ном зүй

Болор, Д. (2018). *Компанийн гүйцэтгэх дээд удирдлага буюу CEO*. Улаанбаатар.

- БСШУСЯ. (2018). *Тогтвортой хөгжил дээд боловсрол*. Улаанбаатар.
- Буянтогтох, Н. (2018). *Төрийн удирдлага мэргэжлээр төгсөгчдийн хөдөлмөр эрхэлэлтийн судалгаа бакалаврын төгсөлтийн ажлын автореферат*. Улаанбаатар.
- Даваа, Ж. (2015). *Их, дээд сургууль, коллежийн сургалтын хөтөлбөр боловсруулах арга зүй*. Улаанбаатар.
- Дашжамц, Д. (2006). *Техник, технологийн хөгжил ба их сургуулийн шинжлэх ухаан*. Улаанбаатар.
- Марал-Үжин, Б. (2018). *Өрхийн эрүүл мэндийн төвөөр үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгаа. Нийгмийн хөгжил: Асуудал, шийдэл*. Улаанбаатар.
- Нямдулам, Т., Одмаа, Д. (2018). *Төрийн удирдлага-20*. Улаанбаатар.
- Одмаа, Д. (2018). *Судалгааны бүтээлийн товчоон*. Улаанбаатар.
- Өлзийхуяг, Б. (2010). *Боловсрол судлал түүний үндсэн агуулга*. Улаанбаатар.
- ХНХЯ. (2016). *Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа 2016*. Улаанбаатар.
- ХСИС. (2017). *Багшийн харилцаа, хандлага ба сургалтын чанар. Нийгэм, хүмүүнлэгийн шинжлэх ухааны инноваци ба дээд боловсролын ерөнхий эрдмийн сургалтын өнөөгийн байдал, хэтийн төлөв*. Улаанбаатар.
- ХУИС. (2010). *Монгол улсын шинжлэх ухааны хөгжилд их сургуулиудын гүйцэтгэх үүрэг*. УБ.
- Увш, П., Хэрлэн, Б. (2017). *Байгууллагын зан үйл*. Улаанбаатар.
- Пүрэвдорж, Ч., Нэмэхжаргал, Т. (2014). *Орчин үеийн багш боловсролын өнгө төрх. Тогтолцооны хандлага ба боловсролын судалгаа*. Улаанбаатар.
- ШУТИС. (2013). *Олон нийттэй харилцах ажил*. Улаанбаатар.
- БСШУСЯ. Дээд боловсролын шинэчлэлийн зураглал. <https://mecss.gov.mn/page/41/>

Student management satisfaction survey on public administration program

Odmaa.D,
Mongolian University of Science and Technology

Abstract

One of the schools that first initiated the "Public Administration" program was the Computer Techniques and Management at MUST and began training in 1998, based on the Order No. 84 of the Minister of Education Culture and Science, dated March 09, 1996. Nowadays, 94 universities operate in Mongolia, and 10 state-owned and non-state universities educate within the framework bachelor, master and doctoral degrees according to "Public Administration". Currently, there are 109 undergraduate students, 28 masters and 2 doctoral students. Our colleagues focus on developing the program in line with international standards, coordinating with the reform of tertiary education and preparing skilled personnel. In this context, a survey on the training program of teachers, learners, graduates and employers has begun methodically since 2018. The paper aims at enhancing and defining current condition of the knowledge, skills, and attitudes of the students and curriculum, processes and results of the "Public Administration" program, methodology of teacher who teaches it, performance, student's knowledge and skill, finding opportunities and ways to improve it. The study included 72 students study in this program in 2017-2018 academic year, quantitative survey results are formed a group below • Student attitudes toward school • Training programs, accessibility, quality and outcomes • The course process, teacher skills and each group attempted to analyze them. The study shows that regarding students' attitudes and their satisfaction with school in some ways students cannot meet their needs due to insufficient for professional textbooks, learning environment, lack of equipment, poor cafeteria service etc. About advantage of their profession, 44.5% of the surveyed respondents said that they have good liquidity, disadvantage is that place of employment is not enough the highest or 30% answered. As result of study, 62.5% of the students considered that curriculum are in line with the needs of our profession and development and 54.8% of the surveyed students are dissatisfied with their profession. Therefore, it is important to plan, reform phases and modify further activities based on the self-assessment of the curriculum and determine its current level.

Keywords

"Public Administration" program, knowledge, skills, and attitudes